



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй 20,400,000.00 (хорин сая дөрвөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар дахин худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Л.Дашдэмбэрэл, Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга Н.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т хүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13-00-074

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
73 дугаар тогтоолын хавсралт



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа
Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	УАЗ-220692, 04-04 БУА, арал:374100В0452227	2011/ 2011	554,0	20,400,000.00	1,750,000.00
	Нийт дүн			20,400,000.00 (хорин сая дөрвөн зуун мянган)	1,750,000.00 (нэг сая долоон зуун тавин мянган)